



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2004 оны 3 сарын 31 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

┌ Төслийг удирдах нэгжийг татан буулгах, ┐
шинээр байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Дэлхийн банктэй зөвшилцсөнийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хэрэгжилтийн эхний ээлж дуусч байгаатай холбогдуулан Төслийг удирдах нэгжийг 2004 оны 4 дүгээр сарын 01-нээр тасалбар болгон татан буулгасугай.

Хоёр. Төслийг удирдах нэгжийг татан буулгасантай холбогдуулан Д.Бямбааг Төслийг удирдах нэгжийн захирлын үүрэгт ажлаас 2004 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

Гурав. Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Төслийг удирдах нэгжийг шинээр байгуулсугай.

Дөрөв. Шинээр байгуулагдаж байгаа Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах 2 дахь төслийг удирдах нэгжийн захирлаар Лхамсүрэнгийн Бадамхорлоог 2004 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс томилж, үндсэн цалинг Төслийг удирдах нэгжийн орон тоо, цалингийн санг Дэлхийн банктэй зөвшилцөн тогтоох хүртэл 380000 төгрөгөөр түр тогтоосугай.

Тав. Төслийг удирдах нэгжийн дүрэм, орон тоо, цалингийн сан, ажилтнуудыг томилох саналаа боловсруулж, 2004 оны 4 дүгээр сарын 15-ны дотор танилцуулахыг Төслийг удирдах хорооны дарга, Улаанбаатар хотын ерөнхий менежер /Т.Бадамжунай/, Төслийг удирдах нэгжийн захирал /Л.Бадамхорлоо/ нарт тус тус даалгасугай.


Зургаа. Улаанбаатар хотын Нийтийн аж ахуйг сайжруулах эхний төслийг удирдах нэгжийн үндсэн хөрөнгө, төслийн хүрээнд хэрэгжиж дуусаагүй байгаа ажил, түүнтэй холбогдох хөрөнгийг тооллогын комисс байгуулан хууль тогтоомжид заасны

Zak-04

0200431

дагуу 2 дахь Төслийг удирдах нэгжид хүлээлгэн өгөхийг Төслийг удирдах нэгж /Д.Бямбаа/-д үүрэг болгосугай.

Долоо. Төслийг удирдах нэгжийн Монголын талаас гаргах зардлын тооцоог хийж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөхийг Улаанбаатар хотын ерөнхий менежер /Т.Бадамжунай/, Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Ч.Бат/, Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД